

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг тус тус үндслэн ТУШААХ нь:

1. “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв (Н.Эрдэнэхүү)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/329 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай хорт хавдрын болон хавдрын бус архаг хүнд өвчтэй үйлчлүүлэгчийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамруулах, тусламж, үйлчилгээ үзүүлэх, бүртгэх, мэдээлэх, тайлагнах, хянах асуудлыг зохицуулна.

1.2. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага энэхүү журмыг мөрдлөг болгон хүнд хэлбэрийн өвчний улмаас эрүүл мэндийн байдалтай холбоотой ноцтой шаналгаатай (serious health-related suffering SHRS) бүх насны хүмүүст, ялангуяа амьдралын төгсгөлд байгаа хүмүүс, тэдний гэр бүл, асран хамгаалагчдын амьдралын чанарыг **дээшлүүлэхэд** анхаарч ажиллана.

1.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харъяалах нутаг, дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мөн хүлээн авах үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй.

1.4. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага (бүх шатны эрүүл мэндийн байгууллага, хоспис) хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг холбогдох стандарт, зааврын дагуу хэвтүүлэн эмчлэх, гэрээр, өдрөөр, амбулаториор, холимог хэлбэрээр үзүүлнэ.

1.5. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай хавдрын бус оноштой өвчтөнг хэвтүүлэн эмчлэх орны тоог хавдрын хожуу шатны үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх орны тооноос тусад нь төлөвлөж зохицуулна.

1.6. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх таатай орчин бүрдүүлсэн, зориулалтын өрөө тасалгаа, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байна.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

2.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв

2.1.1. Тухайн мэргэжлийн чиглэлээр хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй чанартай үзүүлэхэд үндэсний хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

2.1.2. Эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

2.1.3. Эрхтэн системийн өвчлөл төгсгөлийн шатанд орсон, эмчилгээ үр дүнгүй, эсвэл эмчилгээний эрсдэл ихтэй, амь насанд нь аюултай болсон өвчтөнг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд шилжүүлэх тухай шийдвэрийг гаргана.

2.1.4. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг цаашид хэрхэн үзүүлэх талаар өвчтөн, түүний гэр бүлийнхэнд тайлбарлаж, зөвшөөрөл авсны дараа аймаг, дүүрэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд цахимаар **заавал мэдэгдэж** шилжүүлнэ.

2.1.5. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамруулах шийдвэрийг энэхүү журмын 3-т заасан шалгуур, тухайн өвчний олон улсын ангиллын дагуу төрөлжсөн мэргэшлийн болон лавлагаа шатлалын мэргэжлийн эмч нарын дүгнэлтээр шийдвэрлэнэ.

2.1.6. Холбогдох стандарт, заавар боловсруулж, батлуулж хэрэгжилтэд үнэлгээ хийж ажиллана.

2.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

2.2.1. Аймаг, нийслэлийн хэмжээнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар ханган ажиллана.

2.2.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагыг хөнгөвчлөх эмчилгээний эмч, сувилагч, туслах сувилагч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнаар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулна.

2.2.3. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлнэ.

2.2.4. Орон нутгийн хэмжээнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний байдалд хяналт, үнэлгээ хийж, дүнг Эрүүл мэндийн яаманд тайлагнана.

2.2.5. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв болон **бусад хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэгч** байгууллага:

- Өрх, сумын эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс холбогдох журмын дагуу илгээсэн үйлчлүүлэгчид хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- Хавдрын болон хавдрын бус хөнгөвчлөхийн тус бүр **5 ороос дээш** хэвтүүлэн эмчлэх тасагтай байна.
- Тус 4-6 оронд нэг хөнгөвчлөхийн эмч, 1-3 оронд нэг хөнгөвчлөхийн сувилагч ажиллана.
- Хөнгөвчлөхийн тасаг нь хими эмчилгээний ор, тасгаас тусдаа байна.
- Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд мэргэшсэн эмч, сувилагч, туслах сувилагч ажиллах ба шаардлагатай тохиолдолд олон мэргэжлийн баг тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв:

2.3.1. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний заалт бүхий иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлж, шаардлагатай тохиолдолд үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн байгууллагад хүсэлт илгээж, эргэх холбоотой ажиллана:

- Нарийн төвөгтэй эмчилгээ шаардсан тохиолдолд олон мэргэжлийн багтай хамт төрөлжсөн мэргэшлийн тусламж үзүүлдэг байгууллагад шилжүүлнэ.

- Тусламж, үйлчилгээний тасралгүй байдал, хяналт, бүртгэлийг хийж эргэн мэдээлэх үүрэг хүлээнэ.

- Өвдөлт намдаах, эм бэлдмэлийг журмын дагуу жороор олгох, өвдөлт намдаах, шинж тэмдгийн эмчилгээ, сувилгааг батлагдсан стандарт, журмын дагуу үзүүлнэ.

- Иргэний эрүүл мэндийн дэвтэрт үзүүлсэн тусламж, үйлчилгээ, зөвлөгөөг нарийвчлан тэмдэглэнэ.

- Үйлчлүүлэгчийн ар гэр, асран хамгаалагчдад хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх талаар сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөхдөө холбогдох хууль, эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.3.2. Хөнгөвчлөхийн гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг энэхүү журмын 3.6-д заасан шалгуурын дагуу үзүүлнэ.

Гурав. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамруулах шалгуур.

3.1. Аль нэг эрхтэн, системийн өвчлөлийн хүнд шатанд орсон, эдгэрүүлэх эмчилгээ үр дүнгүй болсон, архаг, даамжрах явцтай, тавилан муутай, амьдралын төгсгөлийн шатанд орсон, өвчтөний амьдрах хугацаа хязгаарлагдмал гэж тооцогдож байгаа тохиолдолд өвчтөнийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамруулна.

3.2. Үйлчлүүлэгчийг хөнгөвчлөх эмчилгээнд шилжүүлэх эсэхийг олон мэргэжлийн эмч, өвчтөн, түүний гэр бүлийнхэнтэй зөвлөлдөн шийдвэрлэнэ.

3.3. Өвчтөний амьдрах хугацаа нэг жил орчим болсныг барагцаалах шалгуурт:

- Өвчин эхэлж, даамжирсан эмгэг жам, түүх,
- Цаашдын эмчилгээнд үр дүн үзүүлэх магадлал, гарч болох эрсдэл,
- Өвчтөний амин эрхтний үйл ажиллагааны байдал,
- Өвчтөний биеийн ерөнхий байдал
- Ноцтой хавсарсан эмгэг байгаа эсэх,
- Карнофскийн үнэлгээгээр оноо 50 юм уу түүнээс бага болсон зэрэг дээр үндэслэн шийдвэрлэнэ.

3.4. Өвчтөн өөрөө болон гэр бүл нь хөнгөвчлөх эмчилгээ хийлгэхийг зөвшөөрч байгаа эсэх нь хамгийн гол үндэслэл, шалгуур болно. Магадлах зорилгоор шалгуурыг давтан хийж болно.

3.5. Хөнгөвчлөхийн хэвтүүлэн эмчлэх шалгуур:

- Хүчтэй өвдөлтийг гэрийн нөхцөлд эмчлэх боломжгүй;
- Амьсгал давчдах шинжийг гэрийн нөхцөлд намжаах боломжгүй;
- Цус алдалтыг гэрийн нөхцөлд эмчлэх боломжгүй;
- Үйлчлүүлэгч ба гэр бүлийн гишүүд айдас түгшүүрт автсан, сэтгэл түгших дайралтад орсон;
- Яаралтай мэс ажилбар шаардагдах тохиолдол- хэвлий, цээжний хөндийн шингэн соруулах, янз бүрийн түгжрэлийн шалтгаанаар бүдүүн нарийн гэдэсний цорго гаргах мэс засал, ходоодонд гуурс тавиулах, давсганд яаралтай гуурс тавиулах, өвдөлт намдаах зорилгоор нугасанд гуурс тавиулах гэх мэт;
- Нугас дарагдах, гэнэт саажих;
- Тархины үсэрхийллийн улмаас таталт өгөх болон гэрийн нөхцөлд эмчлэх боломжгүй байх;
- Хурц гиперкальцеми;
- Гол судсанд бүлэн бөглөөс үүсэх
- Парентераль тэжээл шаардлагатай болох;
- Гэртээ асрах сувилах хүнгүй, өөртөө үйлчлэх чадваргүй ганц бие үйлчлүүлэгч;
- Үйлчлүүлэгчийн ар гэрийг амраах, түр амсхийх боломж олгох зорилгоор 5-10 хоног хэвтүүлэх;

- Хавдрын шарх болон, хэвтрийн цооролт, стом зэрэг нь халдвар авч хүндэрсэн;
- Үйлчлүүлэгчид өдөр бүр цагийн тариа дусал хийх шаардлагатай боловч гэрийн нөхцөлд хийлгэх боломжгүй.

3.6. Хөнгөвчлөхийн гэрээр үзүүлэх шалгуур:

Хөнгөвчлөх асаргаа, сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгчдэд Карновскийн үнэлгээ, өвдөлтийн үнэлгээ, бусад эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны үнэлгээ хийж, үнэлгээний дүнд үндэслэн шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ:

- Хэвтрийн холголт цооролттой,
- хавдрын үл эдгэрэх шархтай өвчтөнд,
- Өтгөн хаталттай буюу шингэн алдах үед,
- Шээс хаагдсан эсвэл задгайрсан үед,
- Өвчтөн, ар гэрийн хүсэлтээр,
- Гастростом, колостом, цистостомтой өвчтөний стомын арчилгаа, сувилгаа шаардлагатай үед,
- Өвдөлтийн зэрэг, хэлбэр, шинж чанар, шалтгааныг тогтоох,
- Эмчийн зөвлөсөн эмчилгээг хийх,
- Өвчтөн гэртээ нас барсан тохиолдолд,
- Бусад.

Дөрөв. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд баримтлах зарчим, үнэлгээ, хүртээмж, тасралтгүй байдал

4.1. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд баримтлах зарчим

4.1.1. Байгууллагын баримтлах зарчим

- 1. Үйлчлүүлэгч ба гэр бүл төвтэй тусламж, үйлчилгээний зарчим:** Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн эрхийг нь хамгаалсан, хүндэтгэсэн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Насанд хүрээгүй, эсвэл шийдвэр гаргах чадваргүй үйлчлүүлэгчийн асуудлаар гаргах аливаа шийдвэрт өөрийнх нь саналыг заавал харгалзан тусгана.
- 2. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн амь насанд аюултай, эсвэл эрүүл мэндийн хувьд эдгэшгүй, хүнд нөхцөлд орсныг нь оношилсон цагаас эхлэн нас барах, мөн түүнчлэн гэр бүлийн гишүүдийн уй гашууг хуваалцах хүртэл тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа болно.
- 3. Тусламж үйлчилгээний цогц байдлын зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь өвчтөний эрүүл мэндийн байдлыг бие бялдар, сэтгэл зүй, нийгэм, оюун санааны хувьд нь тодорхойлж, үнэлгээ өгөх, оношлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны бүрдэл болно.
- 4. Салбар хоорондын хамтын ажиллагааны зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ нь холбогдох бүх шатны байгууллага, олон мэргэжлийн багийн хамтын ажиллагаатай байна.
- 5. Тусламж үйлчилгээний удирдлагын тасралтгүй байдлыг хангах зарчим:** Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь нэгдсэн удирдлага, зохион

байгуулалтаар хангагдсан, тусламж үйлчилгээг үзүүлэх арга аргачлал, арга зүйн хувьд **нэгдмэл байна.**

6. Тэгш байдлыг хангах зарчим: Хөнгөвчлөх тусламж үзүүлэгч бүх шатны байгууллага, эрүүл мэндийн мэргэжилтэн нь **арьсны өнгө, хүйсийн байдал, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, өвчин, нас хүйсийг харгалзахгүйгээр тусламж үйлчилгээг үзүүлнэ.**

7. Үхлийг хурдасгахгүй, мөн саатуулахгүй байна.

4.1.2 Эрүүл мэндийн байгууллагын ажилтны баримтлах зарчим

- 1. Халамжтай хандлагын зарчим:** Зөвхөн эрүүл мэндийн тусламж бус, тухайн хүнд мэдрэмтгий, өрөвдөх, энэрэн нигүүлсэх сэтгэлтэй хандаж хүний бүхий л зовлон зүдгүүрийн талаар санаа тавьж, хүн бүрийн өвөрмөц хэрэгцээ өөр гэдгийг ойлгож үзүүлнэ.
- 2. Өвдөлтүй, зовиур шаналгаагүй байлгах зарчим:** Өвдөлт намдаах нь бие махбодь, сэтгэл зүй, нийгэм, оюун санааны талыг багтаасан чухал тусламж, үйлчилгээ байна. Амьдралын төгсгөлд ойртож буй хүмүүсийн хувьд өвдөлтийг тасралгүй үнэлэн, менежмент хийх нь маш чухал юм.
- 3. Үйлчлүүлэгчийн (хүүхэд насанд хүрэгч) өвөрмөц сэтгэл зүйд тулгуурласан тусламж, үйлчилгээний зарчим:** бүх насны, архаг болон амь насанд нь аюул учруулсан өвчин эмгэгтэй хүмүүсийн бие бялдар, нас, сэтгэл зүйд тулгуурласан гэнэтийн тохиолдлыг даван туулах арга замыг тодорхой болгох, хувь хүн болон гэр бүлийн ачааллыг бууруулахад чиглэсэн тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 4. Харилцааны ур чадварын зарчим:** Үр дүнтэй харилцаа холбоог бий болгох нь тухайн хүний амьдралын төгсгөлийн хүслийг гэр бүлийнхэнд нь хүргэж, цаг нь ирэхэд биелүүлэхэд тусладаг юм. Мэдээлэл солилцох, идэвхитэй сонсогч байх, хэрэгцээг тодорхойлж шийдвэр гаргах, өвчтөн түүний гэр бүлийн гишүүдийн идэвхитэй хамтрагч байх шаардлагатай.
- 5. Өвчтөн болон тэдний гэр бүлийг дэмжих, уй гашууг хуваалцах зарчим:** Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэгч эрүүл мэндийн мэргэжилтэн нь өвчтөний биеийн байдлыг бодитойгоор үнэлэх ур чадвартай, зайлшгүй ирэх мөчийг урьдчилан таамаглаж, гэр бүлийн гишүүдэд үнэн мэдээллийг хүргэх, уй гашууг нь хуваалцах, зөвлөх үүрэгтэй. Гэр бүл нь үхлийн талаар болон зайлшгүй тулгарах нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэл, бэлтгэлтэй байх ёстой.

4.1.3 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний ёс зүйн зарчим

Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн зарчмууд нь бие даасан байдал, ашиг тус, хор хөнөөлгүй байдал, шударга ёс юм.

- 1. Бие даасан байдлын зарчим:** Хувь хүн зовиур шаналгаага арилгахын тулд эрүүл мэндийн үйлчилгээг бие даан сонгох боломжоор хангах ёстой. Хэрэв бие даасан эрх мэдлээ хэрэгжүүлсний үр дүнд учирч болох хор хөнөөл их байвал түүнийг хязгаарлах эрхтэй байх зарчим. Хувь хүний үнэт зүйл, итгэл үнэмшил, зорилгод тулгуурлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шийдвэр гаргах эрхийг хүндлэх зарчим юм.
- 2. Ашиг тусын зарчим:** Хүний салшгүй нэр төрийг үргэлж хүндэтгэн, өвчтөн аль болох урт удаан хугацаанд ая тухтай амьдрах боломжийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаа

явуулах хэрэгтэй. Тусламж, үйлчилгээний хэрэгцээг үйлчлүүлэгч өөрөө сонгох боломжтой байх бөгөөд сонголт нь түүний хувьд ашигтай байх зарчим юм. Хэрэв өвчтөн шийдвэр гаргах чадваргүй, эсвэл өвчтөн эдгэршгүй өвчтэй болсон тохиолдолд өмнө нь өөрийн хүсэл мөрөөдлөө баримтлаагүй бол тухайн өвчтөн болон өвчтөний төрөл төрөгсөд, өвчтөний эрүүл мэндийн төлөөлөлтэй зөвлөлдсөний үр дүнд амьдралын эцсийн шийдвэрийг өвчтөний эмч гаргана.

3. Хор хөнөөл учруулахгүй байх зарчим: **Өгөөмөр** байхаас гадна "хор хөнөөл учруулахгүй" гэсэн ойлголт нь ялангуяа амьдралын сүүлчийн мөчид байгаа хүний хувьд чухал ач холбогдолтой юм. Энэ нь эрүүл мэндийн тусламж үзүүлэгч, асран хамгаалагчийн зүгээс санаатайгаар хохирол учруулахгүй байх үүрэг юм. Ёс суртахуунтай шийдвэр гаргах үндсэн дөрвөн зарчмын хамгийн чухал зарчим бол хор хөнөөл учруулахгүй байх явдал юм.

4. Шударга байх зарчим: Шударга ёс нь өвчтэй хүмүүс болон тэдний гэр бүл, ажил мэргэжил, цаашлаад олон нийтийг хамарсан бусад бүх хүмүүст шударга хандаж, хязгаарлагдмал нөөцийг хариуцлагатай, ухаалаг ашиглахыг шаарддаг. Нэмж дурдахад нэр төр (өвчтөн болон хүмүүс нэр төрөө хүндэтгэх ёстой), үнэнч шударга байдал (мэдээлэлжсэн зөвшөөрөл, үнэнийг хэлэх гэсэн ойлголт).

4.2. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдал

4.2.1 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг хүсч буй үйлчлүүлэгч бүрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, тасралтгүй, **шаардлагатай тохиолдолд олон мэргэжлийн багаар** үзүүлнэ.

4.2.2. Бүх шатны, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага нь **тус журмын 1.5-д заасны дагуу хослуулан үзүүлж болох бөгөөд байгууллага бүр үйлчлүүлэгчийг хэвтүүлэх, шилжүүлэх, гаргах, хянах журам боловсруулж мөрдөнө.**

Тав. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний төрөл, зонхилон үзүүлэх тусламж, үйлчилгээ

5.1. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ.:

- Эмэн болон эмэн бус эмчилгээ: эмэн, туяа, хими, мэс засал, үнэр, дуу хөгжим, зураг, иог, бясалгал гэх мэт эмчилгээ,
- сувилахуйн тусламж, үйлчилгээ,
- сэтгэц– нийгмийн тусламж, үйлчилгээ,
- ёс зүй ухамсар, оюун санааны тусламж, үйлчилгээ,
- нэр хүндийг хадгалах, хямралын үеийн тусламж, үйлчилгээ,
- нийгмийн тусламж, үйлчилгээ,
- гэр бүлийн гишүүдийг түр зуур сэлгэн амраах тусламж, үйлчилгээ,
- хүнд гарз хохирол, уй гашууг тайлах тусламж, үйлчилгээ
- нас баралтыг удирдах.

5.2. Дээрх хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн гол илрэх шинж тэмдэг, хам шинж, зонхилон тохиолдох хямралыг үнэлэн, түүнд тохирсон өвөрмөц тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Зургаа. Тайлан мэдээ

6.1. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь **хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний талаарх статистик мэдээг жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайлагнана.**

6.2 **Эмнэлгийн нөхцөлд хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдаж байхдаа нас барсан тохиолдлыг эмнэлгийн нас баралтад тооцож, харин эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтээс ээлтэй нас баралт гэж үзэж хасаж үр дүнг тооцно.**

6.3. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамрагдаж байгаад эмнэлэгт нас барсан тохиолдолд Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Эмгэг судлалын шинжилгээ хийх журам шинэчлэн батлах тухай” А/447 дугаар тушаалын 2.2 заалтыг мөрдөнө.

Долоо. Хяналт, үнэлгээ

7.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага хооронд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийг шилжүүлэх, хүлээн авах ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна.

7.2. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага нь MNS5455-1:2005 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт болон холбогдох тушаал, дүрэм, зааврын хэрэгжилтийг хангаж ажиллана.